



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/71/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261740 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн Гроут финанс Аудит ХХК-ийн
Захирал Б.Бямба
Утас: 99094391 Цахим хаяг: byambaa@growthfinance.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал.....	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
8. Аудитын илрүүлэлт	17
8.1 Залруулсан алдаа	17
8.2 Төлбөрийн акт.....	17
8.3 Албан шаардлага	17
8.4 Зөвлөмж.....	18
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20
10. Хавсралт: Албан шаардлага	23

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОНУ	Байгал орчны нөлөөллийн үнэлгээ
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТНАЛТ	Тавантолгой нүүрс ачилт логистикийн төв
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ЭТТ ХК	Эрдэнэс-Тавантолгой ХК
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/629
танай _____-ны № _____-т

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.УДААНЖАРГАЛ ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тавантолгой төмөр зам ХХК нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Засгийн газрын 2021 оны 89 дүгээр тогтоолоор Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд болон Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд "Тавантолгойн нүүрс ачилтын логистикийн төв"-ийг барих Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан хянаж, баталгаажуулах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажлыг эхлүүлэхийг даалгасан байна. Дээрх шийдвэрийн дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор уг ажлыг Тавантолгой төмөр зам ХХК-аар гүйцэтгүүлж, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2021 оны хөрөнгө оруулалтын төсөвт батлагдсан 217,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээний дагуу олгохоор шийдвэрлэсэн байна.

Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв байгуулах төслийн техник эдийн засгийн үндэслэлийг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж, Ашигт малтмал, газрын тосны газрын дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр магадлуулахаар хүргүүлжээ. 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдөр тус төслийн Ерөнхий гүйцэтгэгч компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан Барилга угсралтын ажил эхэлсний дараа Төслийн удирдлагын газраас хяналт хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

001051133

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын төслийг хэрэгжүүлэхээр сонгогдсон Ерөнхий гүйцэтгэгчтэй холболтын төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, барилгын ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор 2021 онд нийт орлогыг 4,755.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,555.6 сая төгрөгөөр, ашгийг 200.0 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 4,898.7 сая төгрөгийн орлого олж, 4,547.9 сая төгрөгийн зардал гарган, 350.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

2021 онд тавилга эд хогшил, компьютер техник хэрэгсэл, багаж хэрэгсэл, цахилгаан хэрэгсэл, программ хангамж буюу үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж 2,726.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төсөвлөснөөс 1,277.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авалт хийсэн байна.

Байгууллага гэрээний дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд мэргэжлийн боловсон хүчний бүрэлдэхүүн захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн төслийн гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэлийг багц бүрээр баталгаажуулдаг байна. Тайлант хугацаанд Ерөнхий гүйцэтгэгчээс ирүүлсэн багц тус бүрийн ажлын тоо хэмжээ, гүйцэтгэсэн ажлын хувийн жинг гүйцэтгэл тус бүрээр шалгаж, төлбөрийн дүнг тодорхойлон холбогдох газар, хэлтэс /нэгж/-тэй хамтран нийт 5 удаагийн төлбөрийн баталгаажуулалт хийсэн байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 139 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 92.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан гэж тайлагнасан байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн дээд, доод бүтцийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 82.0 хувь, өртөө зөрлөгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 26.3 хувьтай ба Тавантолгой төмөр зам ХХК нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу захиалагчийн хяналтын ажлыг гүйцэтгэж, уг гүйцэтгэлийг захиалагч болон гүйцэтгэгч талуудын баталгаажуулсан дүнгээр санхүүгийн тайланд тусгасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,659,530,392.87	12,377,371,127.67
1.1.2	Дансны авлага	600,000.00	12,896,250,620.54
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	290,381,710.83	94,909,027,780.78
1.1.4	Бусад авлага	38,105,760,867.30	729,720,394.48
1.1.6	Бараа материал	540,039,829.05	793,108,263.20
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	95,078,665,239.12	333,974,252,111.32
	Эргэлтийн хөрөнгийн дүн	143,674,978,039.17	455,679,730,297.99
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	243,018,713,638.46	282,885,433,904.71
1.2.2	Биет бус хөрөнгө	13,002,344.13	15,671,618.59
1.2.6	Бусад эргэлтийн бус хөрөнгө	864,491,262,021.93	1,411,895,321,918.81
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,107,522,978,004.52	1,694,796,427,442.11
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,251,197,956,043.69	2,150,476,157,740.09
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	873,467,453.62	79,351,280,000.00
2.1.1.3	Татварын өр	20,497,993.19	43,307,102.35
2.1.1.4	НДШ-ийн өглөг	2,396,617.15	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	45,533,144.00	1,108,995,929.94
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	941,895,207.96	80,503,583,032.29
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	54,018,798.78
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	54,018,798.78
2.2	Өр төлбөрийн нийт дүн	941,895,207.96	80,557,601,831.07
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн	467,503,000,000.00	467,503,000,000.00
2.3.2	- хувийн	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	781,811,969,034.87	1,601,311,127,008.50
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	941,091,800.86	1,104,428,900.52
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,250,256,060,835.73	2,069,918,555,909.02
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,251,197,956,043.69	2,150,476,157,740.09

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого	6,983,947,548.19	2,026,366,063.63
2	Борлуулалтын өртөг	7,380,071,840.22	1,899,740,487.00
3	Нийт ашиг(алдагдал)	(396,124,292.03)	126,625,576.63
4	Түрээсийн орлого	481,309,236.35	2,406,775,560.64
5	Хүүгийн орлого	1,482,872,537.89	409,087,989.63
8	Бусад орлого	5,960,023.00	56,462,866.64
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,323,863,650.79	2,606,024,596.79
12	Бусад зардал		42,106,707.91
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	250,153,850.42	350,820,688.84
19	Орлогын татварын зардал	148,287,253.80	99,651,529.19
20	Татварын дараах ашиг (алдагдал)	101,866,596.62	251,169,159.66
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	101,866,596.62	251,169,159.66
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	8,954,089,341.43	4,898,692,480.54

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	/төгрөгөөр/	
			Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	308,872,700,000.00	835,326,394.24	309,709,026,394.24
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	3,898,810.00	3,898,810.00
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	101,866,596.62	101,866,596.62
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	467,502,000,000.00	472,939,269,034.87	0.00	940,441,269,034.87
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл хэрэгжсэн	-	-	-	-
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	467,503,000,000.00	781,811,969,034.87	941,091,800.86	1,250,256,060,835.73
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(87,832,060.00)	(87,832,060.00)
Залруулсан үлдэгдэл	-	-	853,259,740.86	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	251,169,159.66	251,169,159.66
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	819,499,157,973.63	0.00	819,499,157,973.63
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл хэрэгжсэн	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	467,503,000,000.00	1,601,311,127,008.50	1,104,428,900.52	2,069,918,555,909.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,778,757,266.69	5,784,060,867.28
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,237,564,881.65	3,163,907,361.50
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	9,152,284.00	54,105,818.78
1.1.6	Бусад мөнгөн орлого	532,040,101.04	2,566,047,687.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	14,931,713,331.09	87,429,319,573.98
1.2.1	Ажиллагчдад төлсөн	4,944,361,538.22	7,452,525,185.06
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,467,143,870.16	901,034,235.83
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	604,596,571.43	650,665,496.06
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	192,192,500.54	133,806,357.80
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,534,125,154.71	1,009,867,712.58
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	932,796,272.24	330,644,831.58
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	31,710,252.04	33,059,795.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	4,224,787,171.75	76,917,715,960.07
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,152,956,064.40)	(81,645,258,706.70)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,482,956,380.47	409,087,989.63
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	1,482,956,380.47	409,087,989.63
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,012,037,650.30	3,273,283,883.77
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,011,237,650.30	3,234,570,605.77
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	800,000.00	38,713,278.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,529,081,269.83)	(2,864,195,894.14)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	87,227,295,335.64
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	87,227,295,335.64
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	87,227,295,335.64
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(10,656,704,873.32)	2,717,840,734.80
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,341,567,727.10	9,659,530,392.87
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,659,530,392.87	12,377,371,127.67

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны гүйцэтгэл		Зөрүү	Хувь
			төлөвлөгөө	гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	5,713,402.0	48,602,056.4	13,604,874.7	(34,997,181.7)	27.9
	Захиалагчийн хяналтын ажил (ТТ-ГС)	5,713,402.0	24,800,000.0	12,653,962.8	(12,146,037.2)	51.0
	Захиалагчийн хяналтын ажил (Холболтын төмөр зам)	-	814,140.0	439,983.8	(374,156.1)	54.0
	Захиалагчийн хяналтын ажил (Богдхан төмөр зам)	-	22,987,916.4	510,928.0	(22,476,988.4)	22.0
2	Нийт орлого	8,954,173.2	4,755,652.6	4,898,692.5	143,039.8	103.0
	Үүнээс: Цэвэр борлуулалт	6,983,947.5	2,221,652.6	2,026,366.0	(195,286.6)	91.2
	Хүүгийн орлого	1,482,956.4		409,087.9		
	Түрээсийн орлого	481,309.2	2,534,000.0	2,406,775.5	338,326.4	113.3
	Бусад орлого	5,960.0		56,462.8		
3	Нийт зардал	8,703,935.5	4,555,652.6	4,547,871.8	(7,780,878.3)	99.8
	Үүнээс: Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	7,380,071.8	2,221,652.6	1,899,740.5	(321,912.2)	85.5
	Ерөнхий ба удирдлагын зардал	1,323,208.1	2,334,000.0	2,606,024.6	272,024.6	111.6
	Бусад зардал	655.5	-	42,106.7	42,106.7	-
4	Нийт ашиг, алдагдал	250,237.7	200,000.0	350,820.7	150,820.7	175.4

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжихтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 11-нээс 3 дугаар сарын 15-ны хооронд Гроут финанс Аудит ХХК-ийн, Аудитор М.Насанбат, Т.Ариунжаргал, Ү.Цэцэгмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын менежер Ч.Хүнбиш, захирал Б.Бямба хэрэгжүүлсэн.

Тавантолгой төмөр зам ХХК нь 2021 оны санхүүгийн тайланг Гроут финанс Аудит ХХК-д 2022 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 1/143 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн Дотоод аудитын алба нь дарга, санхүүгийн шинжээч, худалдан авах ажиллагааны шинжээч, суурь бүтцийн шинжээч гэсэн 4 хүний орон тоотой ажилладаг.

Тус алба нь үндсэн болон туслах үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, дотоод аудит хийх замаар учирч болох эрсдэлийг үнэлж, дүгнэн холбогдох газар, хэлтэс /нэгж/-ийн дарга нарт санал дүгнэлт гарган, зөвлөмжийг өгч, байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах үүрэгтэй байна. Чиг үүргийн хүрээнд төлөвлөгөөт 20, төлөвлөгөөт бус 20 ажлыг хэрэгжүүлж нийт 212 зөвлөмж өгч ажилласан бөгөөд 2 ажил хэрэгжих шатандаа байна.

Засгийн Газрын 2020 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн ээлжит хуралдааны 48 дугаар тэмдэглэлээр өгсөн чиглэлийн дагуу Сангийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн “Эрдэнэс тавантолгой ХК-ийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хөрөнгийн зарцуулалтад хийх шалгалтын удирдамж”-ийн дагуу 2019, 2020 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд шалгалт хийж, 2021 оны 2 дугаар сард дуусган үр дүнг танилцуулсан байна.

Уг шалгалтаар Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын төсөл, төслийн ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгосон шийдвэр болон “ЕРС” 3-н талт гэрээ байгуулж ажилласан талаар, уг төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, төслийн гүйцэтгэл, тус төмөр зам дээр өмнө гүйцэтгэсэн ажлыг баталгаажуулсан байдал, төмөр замын бүтээн байгуулалтын ажлын техник, эдийн засгийн үндэслэл зэргийн талаар шалгасан. Шалгалтаар тодорхой дүгнэлтүүдийг гаргаж, үйл ажиллагааг сайжруулах 7 зөвлөмжийг өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн тайлангийн цэвэр хөрөнгийг сонгож, дотоод хяналтын үр дүнтэй байдлыг харгалзан материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэлэн 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны цэвэр хөрөнгийн дүн 15,481.5 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 6,251.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын гүйцэтгэлийн шатанд дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Тавантолгой төмөр зам ХХК нь төмөр замын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийг дэмжсэн аюулгүй тээвэр логистикийн сүлжээг өргөжүүлэн зам, тээврийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөрөнгө оруулалтын өгөөж, ашигтай ажиллахад чиглэнэ.

Энэхүү зорилтын хүрээнд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар дүрэмдээ тусгажээ. Үүнд:

- Төмөр замын суурь бүтэц барих;
- Төмөр замын суурь бүтэц ашиглах;
- Суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн засварлах;
- Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн үндсэн төмөр замын суурь бүтэц барих зөвшөөрлийг Тавантолгой төмөр зам ХХК-д олгосон байна. Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр зам нь Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх ба Тавантолгой нүүрсний уурхайгаас Гашуунсухайт боомт хүртэл жилд 30 сая тонн нүүрс тээвэрлэх хүчин чадал бүхий 2 өртөө, 5 зөрлөгтэй, нийт 240 километр урт төмөр замын байгууламж юм. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц барьж, байгуулах ажлыг амжилттай хэрэгжүүлж, 2022 оны 7 дугаар сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох 22 километр төмөр замыг барих барилгын ажлын зөвшөөрлийг тус компанид олгосон байна.

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын холболтын барилгын ажлын зөвшөөрлийг Тавантолгой төмөр зам ХХК-д олгосны дагуу төслийг хэрэгжүүлэхээр сонгогдсон Ерөнхий гүйцэтгэгчтэй холболтын төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, барилгын ажил

гүйцэтгэх гэрээг байгуулсан. Гашуунсухайт боомтын хил холболтын зураг төсөл, барилга угсралт, худалдан авалтын гэрээг байгуулах ажил хийгдэж байна.

Засгийн газрын “Тавантолгой нүүрс ачих логистикийн төв байгуулах тухай” 2021 оны 89 дүгээр тогтоолын дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 20 дугаар тогтоолоор “Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв”-ийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг хянан баталгаажуулах, магадлуулах, барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, хүлээлгэн өгөх ажлыг Тавантолгой төмөр зам ХХК-аар үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Мөн Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар Богдхан төмөр замын төслийг барьж байгуулах тусгай зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д олгосны дагуу бүтээн байгуулалтын барилгын ажлыг эхлүүлэх нээлтийн үйл ажиллагааг 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, барилгын ажлыг эхлүүлэн төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Тавантолгой төмөр зам ХХК-ийг Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 242 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж, хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар шийдвэрээр компанийн шинэчилсэн дүрмийг баталжээ. Шинэчилсэн дүрмээр нийт хувьцааны 66 хувийг “Эрдэнэс-Тавантолгой ХК” 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК тус тус эзэмшүүлж шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн Газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Нийгмийн даатгалын тухай хуульд орсон 2021 оны нэмэлт өөрчлөлтүүд;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Тавантолгой төмөр зам ХХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,659.5	12,377.4	2,717.8
Авлага	38,396.7	108,535.0	70,138.3
Урьдчилгаа	95,078.7	333,974.3	238,895.6
Бараа материал	540.0	793.1	253.1
Үндсэн хөрөнгө	243,018.7	282,885.4	39,866.7
Биет бус хөрөнгө	13.0	15.7	2.7
Бусад эргэлтийн бус хөрөнгө	864,491.3	1,411,895.3	547,404.1
Нийт хөрөнгийн дүн	1,251,198.0	2,150,476.2	899,278.2
Өр төлбөр	941.9	80,557.6	79,615.7
Эздийн өмч	1,250,256.1	2,069,918.6	819,662.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,251,198.0	2,150,476.2	899,278.2

Өмнөх оны үзүүлэлтүүдээс дараах дансуудын үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дансны 99.9 хувийг харилцах данс болон хадгаламжинд байгаа мөнгөн хөрөнгө эзэлж байгаа бол кассанд 0.01 хувь буюу 4.0 сая төгрөг байна.

Харилцах данс дахь мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдлийн 46 хувь буюу 5,641.6 сая төгрөг нь банкны харилцах дансанд байршиж, Төрийн банкинд 256.5 сая төгрөг, Тээвэр хөгжлийн банкинд 220.5 сая төгрөг, Голомт банкинд 5,164.6 сая төгрөгөөр тус тус байршиж байгаа ба 54 хувь буюу 6,731.6 сая төгрөг нь Тээвэр хөгжлийн банк болон Голомт банканд богино хугацаатай хадгаламж хэлбэрээр байршиж байна.

Тайлант онд авлага 130,779.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 22,555.7 сая төгрөгийн төлөлт хийснээр авлагын үлдэгдэл 108,535.0 сая төгрөг болсон байна. Үүнээс татвар шимтгэлийн авлага 6,517.3 сая төгрөг, Гашуунсухайт төслийн гүйцэтгэлээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.1.5-д заасны дагуу хувь тэнцүүлэн хасагдуулж байгаа 88,394.8 сая төгрөгийн НӨТ-ийн авлага байна. Мөн Гашуунсухайт төмөр зам төслийн ерөнхий гүйцэтгэгчээс авах захиалагчийн хяналтын орлогыг хуримтлуулж бүртгэснээс 12,896.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэл бүртгэсэн байна.

Тайлант онд Тавантолгой-гашуунсухайт төмөр замын ажлын гүйцэтгэлийн урьдчилгаанд 819,662.5 сая төгрөгийн нүүрсийг санхүүжүүлэгч тал гүйцэтгэгчид шилжүүлснийг бүртгэж авсан байна. Уг урьдчилгаанаас тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, баталгаажуулснаар 653,944.2 сая төгрөгийг дуусаагүй барилга дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 793.1 сая төгрөг болж 253.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант оноос Гашуунсухайт төмөр замын төслийн ажил эрчимжиж материал татан авалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Гашуунсухайт төслийн хүрээнд ерөнхий гүйцэтгэгчээс хүлээн авсан ачааны 100 ширхэг вагоныг хөрөнгөөр бүртгэсэн;
- Чингис Хаан банкин дах хадгаламжийн 2,010.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тухайн банкны төлбөр барагдуулах чадвар алдагдсанаас үүдэн Шүүхийн шийдвэрийн

дагуу Сүхбаатар дүүрэгт байрлах Гэрэгэ тауэр дах оффисийн 476.7м² барилгыг хүлээн авсан.

Бусад эргэлтийн бус хөрөнгө нь хөрөнгө оруулалтын гүйцэтгэлээр 10,740.0 сая төгрөгөөр нэмэгдэн 447,613.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба дуусаагүй барилга буюу төслийн гүйцэтгэл нь 576,340.1 сая төгрөгөөр нэмэгдэн 964,298.1 сая төгрөг болон нэмэгдсэн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 80,557.6 сая төгрөг байгаа ба энэ нь төслийн санхүүжилттэй холбоотой урьдчилгаа төлбөрүүд байна

Тавантолгой төмөр зам ХХК-ийн хувьцаа эзэмшигчид нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 05 дугаар тогтоолоор 467,500.0 сая төгрөгийн үнэ бүхий 187.0 сая ширхэг хувьцааг нэмж эргэлтэд оруулан, нийтдээ 187.0 сая ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх 467,503.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийг бүртгэснээс хойш хувь нийлүүлсэн хөрөнгөнд өөрчлөлт ороогүй. Харин эзэмшигчийн өмч өмнөх оноос 819,662.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хувьцаанд хөрвөхөөр хүлээгдэж байгаа толгой компаниудын хөрөнгө оруулалтын санхүүжилтийг нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Тавантолгой төмөр зам ХХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, удирдах дээд байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй боловч одоогоор толгой компани болон Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан ажиллаж байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээний дагуу хэрэгжиж буй төсөлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллахаар санхүү, эдийн засгийн төлөвлөлтийг хийсэн ба 2021 оны 3 дугаар сараас эхлэн “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замтай холбох “Холболтын төмөр зам”-ын төсөл, 2021 оны 05 дугаар сараас эхлэн “Тавантолгой нүүрс ачих логистикийн төв”-ийн төсөл, 2021 оны 08 дугаар сараас эхлэн “Богдхан төмөр зам”-ын төслүүдэд тус тус захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх болсон.

Санхүү, эдийн засгийн төлөвлөлтийг нөхцөл байдалд тохируулан төлөвлөсөн ба 2021 оны 9 дүгээр сард “Холболтын төмөр зам”, “Тавантолгой нүүрс ачилт, логистикийн төв”, “Богдхан төмөр зам”-ын төслүүдэд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж ажилласан байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 21 тоот тогтоолоор Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2021 онд гүйцэтгэх төслийн ажлын санхүүжилтийг 32,773.4 сая төгрөгөөр баталсан ба тайлант хугацаанд 3 удаагийн тодотгол хийж 48,602.1 сая төгрөгөөр шинэчлэн баталж үүнээс 13,604.9 сая төгрөгийг төслийн санхүүжилтээр хүлээн авч зарцуулсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 4,755.7 сая төгрөгөөр, зардлыг 4,555.6 сая төгрөгөөр, ашгийг 200.0 сая төгрөгөөр төсөвлөн баталж гүйцэтгэлээр 4,898.7 сая төгрөгийн орлого олж 4,547.9 сая төгрөгийн зардал гаргаж 350.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Орлогыг 4,755.6 сая, 4,555.6 Тайлант онд захиалагчийн хяналтын ажлаар 2,026.4 сая төгрөг, хүүгийн орлогоор 409.1 сая төгрөг, түрээсийн орлогоор 2,406.8 сая төгрөг, бусад орлогоор 56.5 сая төгрөгийг тус тус оруулснаар нийт 4,898.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, орлого төлөвлөснөөс 3 хувиар давж биелсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 4,547.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 775.7 сая төгрөг буюу 14.6 хувиар дутуу зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу оффисын барилгын санхүүжилтийн өмнөх оны үлдэгдэл төлбөрт 618.7 сая төгрөгийг тайлант онд төлж, шинэ төслүүд хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан оффисын тавилга, компьютер техник хэрэгсэл, программ хангамжид нийт 658.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах “Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр орон нутаг болон тэдгээрийн нэгдсэн сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанид хөтлөх маяг”-д заасны дагуу тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Гэвч шилэн дансны мэдээллийг толгой компанийн нэгэн адилаар Уул уурхайн сайдын өгсөн чиглэлийн дагуу Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэхээр шийдвэрлэсэн.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Шилэн дансны тухай хуулийн 3.2-т зааснаас бусад мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тендер шалгаруулалт, худалдан авалттай холбоотой мэдээллүүд нь ихэвчлэн төсөлтөй холбоотой учир хуулийн 3.4-т заасны дагуу мэдээлэх үүрэггүй мэдээллүүд байна.

Шилэн дансны хуулийн 3.4-т хамаарахгүй мэдээллээс бусад орлогын 28 гүйлгээнээс 26 гүйлгээг оруулж 89.0 сая төгрөгийн 2 гүйлгээг, зарлагын 86 гүйлгээнээс 84 гүйлгээг мэдээлж, 452.3 сая төгрөгийн 2 гүйлгээг оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн заасны дагуу цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь, бүрэн оруулж байх талаар зөвлөмж өгөх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоол болон 2019 оны 304 дүгээр тогтоолоор Тавантолгой төмөр зам ХХК-ийг байгуулж, хувьцааны 66 хувийг Эрдэнэс Тавантолгой ХК, 34 хувийг Монголын төмөр зам ТӨХК-д тус тус эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн ба тэдгээр хувьцаа эзэмшигчид нь төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд байна.

Гэтэл Тавантолгой ХХК-ийн хувьцаа эзэмшигчид нь төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангаж ажиллахгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.3 “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах,” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалган үзэхэд дараах байдалтай байна.

1. Ковид 19 цар тахалтай холбоотой сул зогсолтын хүрээнд 2020 оны 11 дүгээр сараас 2021 оны 2 дугаар сарыг дуустал ажилтнуудад 60 хувийн цалин олгосон, мөн 2021 оны 6 дугаар сард бүтэц орон тооны өөрчлөлтөөр цалингийн шатлал өөрчилснөөс цалингийн зардлыг хэмнэсэн боловч уг хэмнэсэн зардлаасаа жилийн эцэст ажилтнуудад нэмэгдэл урамшуулал олгосон байна.

2. Гүйцэтгэх захирлын 2021 оны 07 дугаар сарын 30-ны А48 тушаалаар 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн А/81 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан албан тушаалын шатлалд харгалзах цалингийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэн шинэчлэн баталсан, Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар 28-ны өдрийн А79 тоот тушаалын дагуу ажилтнуудад үндсэн цалингийн 60 хүртэлх хувиар ажлын үр дүнгийн нэмэгдлийг олгосон байна.

Эдгээр нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаарх авч хэрэгжүүлж байгаа тогтоолыг хэрэгжүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх;

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомж болон санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зарим асуудлууд нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын зарим заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 1,835.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 1,408.4 сая төгрөгийг залруулж, 35.0 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 391.6 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 136.9 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 20.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс албан шаардлага, зөвлөмж тус бүр 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	136.9	2	136.9	-	-	100.0
Зөвлөмж	3	20.0	3	20.0	-	-	100.0
Нийт дүн	5	156.9	5	156.9	-	-	100.0

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад болон балансын дараа үед хамааралтай доорх асуудлуудыг дараагийн аудитаар анхаарах асуудалд орууллаа. Үүнд:

- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын (цаашид “ЕРС” гэх) санхүүжилтийн гэрээний дагуу Тавантолгой төмөр зам ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтад хүү тооцсон талаар талууд маргаантай байснаас хувьцаанд хөрвүүлэх дүн тодорхой болоогүй өнөөдрийг хүрсэн. Харин талууд уг маргааныг шийдвэрлүүлэхээр Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх арбитра хандсаны дагуу арбитрын 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн шийдвэрээр хөрөнгө оруулалтад хүү тооцох асуудал хүчингүй болсон тул үндсэн гэрээнд өөрчлөлт оруулах, толгой компаниас хувьцаанд хөрвүүлэх дүнг тодорхой болгох 2 асуудал үүсч байна.
- Засгийн газрын 2021 оны 254 дүгээр тогтоолоор Богдхан төмөр замын суурь бүтцийн ажлын зөвшөөрлийг Тавантолгой төмөр зам ХХК-д олгосон. Уг ажлын санхүүжилтийг шийдвэрлэсэн тогтоол, тушаал, холбогдох эрх зүйн баримт бичиг одоогоор гараагүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,561.4 сая төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс, 158.1 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 342.3 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,060.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн. Залруулагдаагүй 1,403.3 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 6,251.3 сая төгрөгийн материаллагийн түвшнээс 4,848.0 сая төгрөгөөр бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 158.1 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- Өмнөх жилд нөхөн төлүүлэхээр тогтоосон 134.7 сая төгрөгийн актыг байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 87.9 сая төгрөгийг тайлант хугацааны зардлаар бүртгэснийг;
- Тайлант хугацаанаас хойшхи үед хамаарах техник тоног төхөөрөмжийн 16.2 сая төгрөгийн даатгалын төлбөрийг барилгын ажлын өртөгт бүртгэснийг;
- Үндсэн хөрөнгийн Санхүүгийн тайлагналын зорилгоор болон татварын тайлангийн зорилгоор байгуулсан, ААНОАТ-ын тайланд тусгаагүй 54.9 сая төгрөгийн элэгдлийн зөрүүг залруулав.

8.2 Албан шаардлага

1. ТУЗ-ийн 7 гишүүнд цалингийн хэмжээг зааснаас илүү буюу тайлант онд нийт 49.9 сая төгрөгийг илүү олгосон байна.

Энэ Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д “цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, холбогдох журмын заалтыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх;

2. Тайлант хугацаанд худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 292.5 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээг худалдан авсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2."Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ." заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх;

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Компани жилийн эцсийн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудыг бэлтгэж толилуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1."Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна;" 8.1.5."санхүүгийн тайлангийн тодруулга," Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлан тодруулгыг иж бүрэн, холбогдох стандарт, журам зааварт нийцүүлэн бэлтгэж байх.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын эзэмшлийн 5 байршилд байгаа газрын хэмжээ нь эзэмших эрхийн гэрчилгээгээр 5,707.04 га боловч газрын мэдээллийн санд 5,473.92 га байгаа нь 233.12 га зөрүүтэй байна. Энэ нь газрын хэмжилт хийх системийн шилжилтийн зөрүүний топологийн алдаанаас үүссэн бөгөөд үүнийг эцэслэн шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалтыг зөрчиж санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эзэмшиж байгаа газрын хэмжээ бүртгэлээс зөрүүтэй асуудлыг холбогдох мэргэжлийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, газрын гэрчилгээн дээрх хэмжээ, мэдээллийн санд байгаа газрын хэмжээг ижил болгож баталгаажуулах;

3. Бараа материалын данс холбоотой асуудал

Илрүүлэлт: Монголын төмөр зам ТӨХК-аас шилжиж ирсэн 843.6 сая төгрөгийн дугуй бетон хоолой, хэв хашмал, гүүрний хүчитгэх тросс гэх мэт хөрөнгүүд бараа материалын дансанд бүртгэлтэй байна. Эдгээр хөрөнгө нь ашиглагдахгүй болсон ба цаашид ашиглах эсэх нь тодорхойгүй, хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгээгүй байна. Мөн ижил шинж чанар бүхий

хөрөнгүүдийг үндсэн хөрөнгө, бараа материал, дуусаагүй үйлдвэрлэл зэрэг дансанд бүртгэж хөрөнгө, зардлыг холбогдох ангиллын дагуу зөв ангилан бүртгээгүй байна.

Энэ нь НББОУС 2-т “Тайлант хугацааны эцэст бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын чанар байдал болон цаашид ашиглагдах хугацааг үнэн зөв тогтоож НББОУС 2-ын дагуу цэвэр боломжит үнээр бүртгэх, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хөрөнгө болон бараа материалын ангиллыг тодорхой тусган холбогдох стандарт компанийн үйл ажиллагаанд уялдуулан шинэчлэн тусгах.

4. Анхан шатны баримт хөтлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Гүйцэтгэх захирлын байгууллагыг төлөөлөх уулзалт, хурал, зөвлөгөөний зардалд сар бүр 3.0 сая төгрөг нийт 36.0 сая төгрөгийг олгохоор ТУЗ-аас шийдвэрлэсэн байна. Тус зардлын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл хангасан, хүчин төгөлдөр баримтыг үндэслэн уулзалт, хурал зөвлөгөөний зардлыг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаж байх;

5. Үлдэх өртөггүй хөрөнгө

Илрүүлэлт: Элэгдлээр анхны өртгөө нөхсөн, үйл ажиллагаанд ашиглагдаж буй 181.3 сая төгрөгийн анхны өртөг бүхий 72 ширхэг хөрөнгийг дахин үнэлж бодит үнэ цэнийг тогтоож бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн бодит үнэ цэнийг НББОУС16-н дагуу тайлант хугацааны эцэст хэмжиж үзэж, бүртгэлд үнэн зөв дүнгээр тусгах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	"Тавантолгой төмөр зам" ХХК	АХГ-2022/71/НА-СТА-ТӨА	Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг мөрдөөгүй, ТУЗ-ийн 7 гишүүнд цалин илүү олгосон байна.	Төсвийг зохистой удирдаж, Төлөөлөн Удирдах зөвлөлийн тогтоосон цалин Засгийн газрын тогтоолоор баталсан цалин хөлсийг олгож байх албан шаардлага хүргүүлэх;	1	49,885.3					1	49,885.3				
2	"Тавантолгой төмөр зам" ХХК	АХГ-2022/71/НА-СТА-ТӨА	Тайлант хугацаанд худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа ажил үйлчилгээг худалдан авсан байна.	Худалдан авалтын төлөвлөгөөг бодиттой, үндэслэлтэй гаргаж, мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх;	1	292,466.9					1	292,466.9				
3	"Тавантолгой төмөр зам" ХХК	АХГ-2022/71/НА-СТА-ТӨА	Элэгдлээр анхны өртгөө нөхсөн, үйл ажиллагаанд ашиглагдаж буй 181.3 сая төгрөгийн анхны өртөг бүхий 72 ширхэг хөрөнгийг дахин үнэлж бодит үнэ цэнийг тогтоож бүртгэлд тусгаагүй байна	Хөрөнгийн бодит үнэ цэнийг НББОУС16-н дагуу тайлант хугацааны эцэст хэмжиж үзэж, бүртгэлд үнэн зөв дүнгээр тусгах;	1	181,300.0							1	181,300.0		
4	"Тавантолгой төмөр зам" ХХК	АХГ-2022/71/НА-СТА-ТӨА	Өмнөх жилд нийгмийн даатгалын шимтгэл суутгалгүй олгосон үр дүнгийн урамшуулалд нөхөн төлүүлэхээр тогтоосон 134,713,556.02 төгрөгийн актны нийгмийн даатгалын зардлыг тайлант хугацааны зардлаар бүртгэсэн байна.	Залруулах	1	87,832.1	1	87,832.1								
5	"Тавантолгой төмөр зам" ХХК	АХГ-2022/71/НА-СТА-ТӨА	Тайлант хугацаанаас хойшхи үед хамаарах техник тоног төхөөрөмжийн даатгалын төлбөрийг барилгын ажлын өртөгт бүртгэсэн байна.	Залруулах	1	16,219.5	1	16,219.5								

Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6	“Тавантолгой төмөр зам” ХХК	АХГ-2022/71/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн Санхүүгийн тайлагналын зорилгоор болон татварын тайлангийн зорилгоор байгуулсан элэгдлийн зөрүүг ААНОАТ-ын тайланд тусгаагүй байна.	Залруулах	1	54,018.8	1	54,018.8												
7	“Тавантолгой төмөр зам” ХХК	АХГ-2022/71/НА-СТА-ТӨА	Байгууллагын эзэмшилд байгаа 5 байршилтай газрын хэмжээ, эзэмших эрхийн гэрчилгээгээр 5,707.04 га хэмжээтэй боловч газрын мэдээллийн санд 5473.92 га буюу гэрчилгээгээрх хэмжээнээс 233.12 га-гаар зөрүүтэй байна. Энэ нь системийн шилжилтийн зөрүүний топологийн алдаанаас үүссэн гэх боловч түүнийг эцэслэн шийдвэрлээгүй байна.	Эзэмшиж байгаа газрын хэмжээ бүртгэлээс зөрүүтэй байгаа асуудлыг холбогдох мэргэжлийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэн баталгаажуулах, гэрчилгээг засварлуулах;	1														1	
8	“Тавантолгой төмөр зам” ХХК	АХГ-2022/71/НА-СТА-ТӨА	Компанийн Санхүүгийн тайлангийн тодруулга, бэлтгэж толилуулаагүй байна.	Санхүүгийн тайлан тодруулгыг иж бүрэн, холбогдох стандарт, журам зааварт нийцүүлэн бэлтгэж байх	1														1	
9	“Тавантолгой төмөр зам” ХХК	АХГ-2022/71/НА-СТА-ТӨА	МТЗ ТӨХК-аас шилжиж ирсэн дугуй бетон хоолой, хэв хашмал, гүүрний хүчитгэх тросс гэх мэт хөрөнгүүд бараа материалын дансанд бүртгэлтэй байна. Эдгээр хөрөнгө нь ашиглагдахгүй болсон ба цаашид ашиглах эсэх нь тодорхойгүй, хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгээгүй байна.	Бараа материалын чанар байдал болон цаашид ашиглагдах хугацааг үнэн зөв тогтоож НББОУС 2-ын дагуу цэвэр боломжит үнээр бүртгэх, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хөрөнгө болон бараа материалын ангиллыг тодорхой тусган холбогдох стандарт компанийн үйл ажиллагаанд уялдуулан шинэчлэн батлах.	1	843,606.8													1	843,606.8
10	“Тавантолгой төмөр зам” ХХК	АХГ-2022/71/НА-СТА-ТӨА	Гүйцэтгэх захирлын байгууллагыг төлөөлөх уулзалт хурал зөвлөгөөний зардал сар бүр 3.0 сая төгрөг олгохоор ТУЗ-аас шийдвэрлэсэн байна. Тус зардлын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	Анхан шатны баримтын бүрдэл хангасан ажил гүйлгээг данс бүртгэлд тусгаж байх, анхан шатны баримтгүй гүйлгээг бүртгэлд тусгахгүй байх;	1	36,000.0													1	36,000.0
ДҮН					10	1,561,361.6	3	158,070.4						1	342,352.2	-	-		5	1.060,939.0

Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал														
11	"Тавантолгой төмөр зам" ХХК	АХГ-2022/71/НА-СТА-ТӨА	Шилэн дансны хуулийн 3.4-т хамаарахгүй мэдээллээс бусад орлогын нийт 28 гүйлгээнээс 26 гүйлгээг оруулж, нийт 89,0 сая төгрөгийн 2 гүйлгээг, зарлагын 86 гүйлгээнээс 84 гүйлгээг мэдээлж, нийт 452.3 сая төгрөгийн 2 гүйлгээг оруулаагүй байна.	Шилэн дансны тухай хуулийн заасны дагуу цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь, бүрэн оруулж байх талаар зөвлөмж өгөх	1	541,300.0							1	541,300.0
12	"Тавантолгой төмөр зам" ХХК	АХГ-2022/71/НА-СТА-ТӨА	Гүйцэтгэх захирлын 2021.07.30-ны А48 тушаалаар 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн А/81 дүгээр тушаалын 2-р хавсралтаар батлагдсан албан тушаалын шатлалд харгалзах цалингийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэн шинэчлэн баталсан, Гүйцэтгэх захирлын 2021.12.28-ны өдрийн А79 тоот тушаалын дагуу ажилтнуудад үндсэн цалингийн 60 хүртэлх хувиар ажлын үр дүнгийн нэмэгдлийг олгосон.	Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаарх авч хэрэгжүүлж байгаа тогтоолыг хэрэгжүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх;	1	709,480.2					1	709,480.2		
ДҮН					2	1,250,780.2	-	-	-	-	1	709,480.2	-	-
НИЙТ ДҮН					12	2,812,141.8	3	158,070.4	1	49,885.3	2	1,001,947.1	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒᠒ оны ᠐3 дугаар сарын 15

№ ᠖᠔᠒/АО-15᠐᠐53

Улаанбаатар хот

АХГ - ᠒᠐᠒᠒ / 71 / 115 - СТА - ГЗА .

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр бүхий 7 гишүүнд Засгийн газраас тогтоосон хувь хэмжээнээс нийт 49,885,300.00 төгрөгөөр илүү цалин олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7 "Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цалин хөлсийг Засгийн газрын тогтоолоор баталсан хязгаарыг баримтлан олгож байх, дээрх зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Удаанжаргал, ерөнхий нягтлан бодогч Б.Цэрэнлхам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР
ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Д.ЭНХДАЛАЙ

Б.БЯМБА **0001081761**



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒᠒ оны ᠐᠒ дугаар сарын ᠕

№ ᠖᠒᠘ /АД ᠒᠐᠒᠑᠘

Улаанбаатар хот

ААТ - ᠒᠐᠒᠒ /᠑᠑ /НА -᠑᠑᠑᠑ -᠑᠑᠑᠑

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаагүй 292,466,930.62 /Хоёр зуун ерэн хоёр сая дөрвөн зуун жаран зургаан мянга есөн зуун гучин төгрөг жаран хоёр мөнгө/ төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2."Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ." заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авалтын төлөвлөгөөг бодиттой, үндэслэлтэй гаргаж, мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг "Тавантолгой төмөр зам"-ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Удаанжаргал, ерөнхий нягтлан бодогч Б.Цэрэнлхам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Б.БЯМБА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

᠑᠐᠑᠑.᠕᠑᠑
᠑᠐᠑᠑.᠑᠑᠑

᠒᠐22᠐315 Аудитын 2 Газрын 80 дүрэм

0001021753



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 604/АБ 0005

Улаанбаатар хот

АТ - 0002 /Н /НА - БА - ТОО .

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын 2021 оны 07 дугаар сарын 30-ны А/48 дугаар тушаалаар 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/81 дүгээр тушаалын 2-р хавсралтаар баталсан албан тушаалын шатлалд харгалзах цалингийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэн шинэчлэн баталсан, Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/79 дугаар тушаалаар ажилтнуудад үндсэн цалингийн 60 хүртэлх хувиар ажлын үр дүнгийн нэмэгдлийг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3-т заасан "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх," гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1. "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийг зохистой удирдаж, Төлөөлөн Удирдах зөвлөлийн тогтоосон цалин Засгийн газрын тогтоолоор баталсан цалин хөлсийг олгож байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Удаанжаргал, ерөнхий нягтлан бодогч Б.Цэрэнлхам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Б.БЯМБА

